9001:2015

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА
ОРХОН АЙМАГ

37001:2016

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА**

# ДОТООД АУДИТОР-САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ О.БОЛОРМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**ОРХОН АЙМАГ**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДОТООД АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ О.БОЛОРМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## *НЭГ. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт*

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| ***ЗОРИЛТ-1 "Бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд*** | | | | | | | |
| 1.1 | Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 29 тоот тушаалаар батлагдсан" **Дотоод аудитын хорооны дүрэм**"-ийн дагуу үйл ажиллагаа явуулж, хорооны хурлаар шийдвэрлэсэн асуудал, хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр холбогдох газарт хүргүүлэх | Хурлын тоо-**/2 удаа/** | - | 50% | **1.** Аймгийн Дотоод аудитын хорооны хурал 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулагдаж хурлаар 4 асуудал хэлэлцэгдсэн. Үүнд:<br>1. 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт, 2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлт,<br>2. Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн дотоод аудитын тайлан, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ (2023 он, 2024 оны I улирал) | 06 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3. Монгол улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор байгууллагын нэршил өөрчлөгдсөн, Сангийн сайдын 268 дугаар тушаалаар "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ыг шинээр баталсантай холбоотойгоор Аймгийн Засаг даргын 2018 оны А/233 дугаар захирамжаар баталсан "Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрэм", Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх журам"-д орсон нэмэлт өөрчлөлтийг төслөөр тусган хэлэлцүүлэх, батлуулах;<br>4. Бусад асуудал (2023 онд хийсэн онцлох ажлууд) Хорооны хурлаар нэмэлт өөрчлөлт оруулсан "Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм", "Санхүүгийн хяналт шалгалт хийх журам", Дотоод аудит хийх журам"-ын төслийг гишүүдийн 100%-ийн саналаар дэмжин Аймгийн Дотоод аудитын хорооны хурлын 01/24 дүгээр тогтоолоор "Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дүрэм", "Дотоод аудит хийх журам", "Санхүүгийн хяналт шалгалт хийх журам"-ыг тус тус батлан үйл ажиллагаандаа мөрдөж байна.<br>**2.** 2024 оны 4-р улиралд ДАХорооны хурал дахин зохион байгуулагдаагүй байна. | | |
| 1.2 | Дотоод аудитад хамрагдсан байгууллагуудын **эрсдэлийг үнэлэх, нэгтгэж мэдээллийн санд оруулах**<br>**Үүнд:**<br>*Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар,*<br>*Орон нутгийн өмчийн газар*<br>*Баян-Өндөр сум ОНХС*<br>*АЗДТГ* | Эрсдэлийн үнэлгээ<br>**/4 байгууллага/** | - | 4 | ***1."Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар"***<br>Тус газрын 2023 оны төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод үйл ажиллагаанд аудит хийж "Эрсдэл үнэлэх журам"-ын дагуу 12 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 6 оноо буюу "*Бага эрсдэлтэй*" гэж дүгнэгдсэн.<br>***2. Орон нутгийн өмчийн газар***<br>Тус газрын 2023 оны төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод үйл ажиллагаанд аудит хийж | 01-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Эрсдэл үнэлэх журам"-ын дагуу 12 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 19 оноо буюу *"Их эрсдэлтэй"* гэж дүгнэгдсэн.<br>***3. Баян-Өндөр сумын ОНХС***<br>Тус сангийн 2023 оны төсөв, санхүү худалдан авах ажиллагаанд аудит хийхэд "Эрсдэл үнэлэх журам"-ын дагуу 12 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 16 оноо буюу *"Дунд эрсдэлтэй"* гэж дүгнэгдсэн.<br>***4.АЗДТГ***<br>Тус газрын 2023 оны төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод үйл ажиллагаанд аудит хийж "Эрсдэл үнэлэх журам"-ын дагуу 12 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 14 оноо буюу *"Дунд эрсдэлтэй"* гэж дүгнэгдсэн. | | |
| 1.3 | Улсын төсөвт байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгэх<br><br>***/Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар/***<br><br>***/Цагдаагийн газар нэмэгдсэн/*** | Аудитад хамрагдах байгууллагын тоо-<br>**/2 байгууллага/** | - | 2 | ***1."Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар"***<br>2023 оны төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод үйл ажиллагаанд аудит хийж гүйцэтгэлээ.<br>Аудитаар 1 асуудал илэрч мэргэжлийн байгууллагаас дотоод хяналт шалгалт хийх арга зүйн зөвлөгөө авч анхан шатны баримтад тулгуурлан оновчтой зөв хяналтыг хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч 2023 оны төсөв санхүү, дотоод үйл ажиллагаар *"ХАНГАЛТТАЙ"* гэж дүгнэсэн.<br>Биелэлтийг ГХБХБГ-ын даргын 2024.07.01-ны өдрийн 439 дугаар албан тоотоор ирүүлсэн.<br>***2. Цагдаагийн газар***<br>Тус газрын 2023 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтаар ноцтой илэрсэн зөрчил дутагдал байхгүй тул 2023 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаар *"ХАНГАЛТТАЙ"* гэж дүгнээд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн Газрын тогтоол шийдвэрүүд болон бусад | 04<br><br><br><br>07 | 100% |



96

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | санхүүгийн холбогдох хууль эрх зүйн акт, байгууллагын дотоод дүрэм журмыг баримтлан ажиллах талаар шалгалтын явцад мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөгөөр хангаж ажиллав.<br>Шалгалтаар 3 зөвлөмж өгч, биелэлтийг Орхон аймгийн Цагдаагийн газрын 2024.10.15-ны өдрийн 42/5653 дугаар албан тоотоор ирүүлсэн байна. | | |
| 1.4 | Орон нутгийн төсөвт байгууллагуудад дотоод аудит гүйцэтгэх<br><br>***/Орон нутгийн эмчийн газар/*** | Аудитад хамрагдах байгууллагын тоо - **/1 байгууллага/** | - | 1 | ***Орон нутгийн өмчийн газар***<br>Орхон аймгийн Засаг даргын 2024.06.11-ны өдрийн 32/24 дугаар удирдамжийн дагуу 2024.06.17-ны өдрөөс эхлэн 14 хоногт шалгахаар аудит хийгдсэн. Тус аудитаар 315 айлын түрээсийн төлбөр тооцоо бүртгэл хөтлөлтийг сайжруулах шаардлагатай гэж үзэж 1 зөвлөмж өгөгдсөн.<br>Зөвлөмжийн биелэлтийг ОНӨГ-ын 2024.08.26-ны өдрийн 593 дугаар албан тоотоор хариуг ирүүлсэн. | 06 | 100% |
| 1.5 | Орон нутгийн тусгай шилжүүлгийн төсөвт байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгэх<br>/4 Байгууллага Үүнд:<br>***2-р сургууль***<br>***2-р цэцэрлэг***<br>***8-р цэцэрлэг***<br>***16-р цэцэрлэг/***<br><br>**Төлөвлөгөөнд өөрчлөлт орсноор АЗДТГ, Баян-Өндөр сумын ОНХС, Орхон АЗЗА ТӨХК, шалгалт хийгдсэн.** | Аудитад хамрагдах байгууллагын тоо **/4 байгууллага/** | - | 3 | Хяналт шалгалт, дотоод аудит хийх ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан тусгай шилжүүлгийн байгууллагуудад хяналт шалгалт хийгдээгүй харин төлөвлөгөөнд өөрчлөлт орж дараах байгууллагуудыг шалгалаа.<br>1. ***АЗДТГ-т дотоод аудит хийгдсэн.***<br>Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 09 сарын 30-ны өдрийн баталсан №48/24 тоот удирдамжийн дагуу дотоод аудит хийгдсэн.<br>Аудитаар нийт 80,319.3 мянган төгрөгийн 6 асуудал илэрсэн бөгөөд 1 актаар 2,391.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоож бусад асуудалд аудитын явцад зөвлөмж өгч, 2023 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа болон засаглал, эрсдэл, дотоод хяналтад "САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ" дүгнэлт гаргасан. | 09 | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Аудитын явцад гарсан алдаа зөрчлийг залруулан ажилласан тухайгаа албан тоотоор ирүүлсэн байна.<br>Актын төлбөрийн барагдуулалтыг хийх хугацаа болоогүй байна.<br>**2. Баян-Өндөр сумын ОНХС-дотоод аудит хийгдсэн.**<br>Аймгийн Засаг даргын 2024.10.28-ны өдрийн 51/24 дугаар баталсан удирдамжийн дагуу Баян-Өндөр сумын ОНХС-д аудит хийж сангийн 2023 оны ажиллагаанд "САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ" дүгнэлт өгсөн.<br>Аудитаар нийт 6 асуудал илэрч, 1 асуудалд зөрчил арилгуулах хугацаатай албан шаардлага гаргаж бусад асуудлыг сайжруулахаар 12 төрлийн зөвлөмж өгч ажилласан байна.<br>Албан шаардлага ба зөвлөмжийн биелэлтийг 2025.01.06-нд авах тул хугацаа болоогүй байна.<br>3. ***Орхон АЗЗА ТӨХК***<br>2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт үргэлжилж гүйцэтгэл-40%-тай байна. | 10<br><br>12 | |
| ***ЗОРИЛТ-2 Хариуцлагын тогтолцоог төлөвшүүлж, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх*** | | | | | | | |
| 2.1 | Санхүүгийн хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын **эрсдэлийг үнэлэх,** нэгтгэж мэдээллийн санд оруулах<br>Үүнд:<br>***20-р сургууль,***<br>***Жаргалант сум ЗДТГ,***<br>***ХББЗА,***<br>***Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн АӨЗ***<br>***Хот тохижуулах газар*** | Эрсдэл үнэлсэн байгууллагын тоо<br>**/5 байгууллага/** | - | 4 | **1. Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ**<br>Тус байгууллагын 2023 оны төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж эрсдэлийн үнэлгээний журмын дагуу 11 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 18 оноо буюу *"Дунд эрсдэлтэй"* гэж дүгнэгдсэн.<br><br>***2. Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн АӨЗ УТҮГ***<br>Тус байгууллагын 2023 оны төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод үйл ажиллагаанд | 03-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ***/Төлөвлөгөөнд өөрчлөлт орсон/*** | | | | санхүүгийн хяналт шалгалт хийж эрсдэлийн үнэлгээний журмын дагуу 11 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 15 оноо буюу *"Дунд эрсдэлтэй"* гэж дүгнэгдсэн.<br><br>**3. Жаргалант сумын ЗДТГ**-ын Тус байгууллагын 2023 оны төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж эрсдэлийн үнэлгээний журмын дагуу 11 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 18 оноо буюу *"Дунд эрсдэлтэй"* гэж дүгнэгдсэн.<br><br>4. ***Хот тохижуулах газар***<br>Тус байгууллагын 2023 оны төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж эрсдэлийн үнэлгээний журмын дагуу 11 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 17 оноо буюу *"Дунд эрсдэлтэй"* гэж дүгнэгдсэн. | | |
| 2.2 | Орон нутгийн төсөвт байгууллагуудын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх Үүнд:<br>***/Жаргалант сумын ЗДТГ Хот тохижуулах газар/*** | Хяналт шалгалтын тоо **/2 байгууллага/** | - | 2 | ***1.Жаргалант сумын ЗДТГ***<br>Тус байгууллагын 2023 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж шалгалтаар нийт 1,313,073.6 мянган төгрөгийн 4 төрлийн зөрчил илэрсэн ба үүнээс 1 актаар 491.6 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, зөрчил арилгуулахаар1,313,382.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага гаргаж, бусад зөрчилд зөвлөмж өгөхөөр арга хэмжээ тооцож үйл ажиллагаанд "Хангалттай бус" гэж дүгнэлт өгөгдсөн.<br>Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Жаргалант сумын ЗДТГ-ын 2024.08.31-ны өдрийн 03/510 дугаар албан тоотоор хариу ирүүлсэн.<br>***2. Хот тохижуулах газар*** | 05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тус байгууллагын 2023 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт хийхэд нийт 77,900.3 мянган төгрөгийн зөрчил дутагдалд холбогдох заавар зөвлөмж өгч, 2 актаар 3,535.7 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, 63,654.8 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай 1 албан шаардлага гаргаж үйл ажиллагааг сайжруулахаар 7 зөвлөмж өгч арга хэмжээ тооцож санхүүгийн үйл ажиллагаанд *"Хангалттай бус"* санал дүгнэлтийг гаргасан.<br>Хот тохижуулах газраас 2024.12.05-ны өдрийн 684 дүгээр албан тоотоор биелэлтийг ирүүлсэн. | 08 | |
| 2.3 | Орон нутгийн тусгай шилжүүлгийн төсөвт байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх<br>***/20-р сургууль/*** | Хяналт шалгалтын тоо<br>**/1 байгууллага/** | - | 100% | Хяналт шалгалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тул тус сургуульд шалгалт хийгдээгүй ба өөр шалгалтаар солигдож хийгдсэн болно. | 01-12 | 100% |
| 2.4 | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын төсөв санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх<br><br>***/Хот байгуулалт барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ/*** | Хяналт шалгалтын тоо<br>**/1 байгууллага/** | - | 1 | **1. Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ**<br>Тус байгууллагын 2023 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийгдэж шалгалтаар нийт 27,014.0 мянган төгрөгийн 8 төрлийн зөрчил илэрсэн ба үүнээс 2 актаар 1,292.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, зөрчил арилгуулахаар 5,355.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага гаргаж, бусад зөрчилд зөвлөмж өгч арга хэмжээ тооцож үйл ажиллагаанд *"ХАНГАЛТТАЙ БУС"* дүгнэлтийг өгсөн.<br>Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг ХББЗА-наас 2024.04.15-ны өдрийн 212 дугаар албан тоотоор хариу ирүүлсэн. | 03 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5 | Улсын төсөвт үйлдвэрийн газруудын төсөв санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт гүйцэтгэх<br><br>***/Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ/*** | Хяналт шалгалтын тоо **/1 байгууллага/** | - | 1 | ***"Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн АӨЗ" УТҮГ***<br>Тус байгууллагын 2023 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийгдэж шалгалтаар байгууллагын үйл ажиллагаа дүрэм журмын дагуу байх боловч дотоод хяналтын үйл ажиллагаа хэрэгжээгүй, тушаал шийдвэр гаргаж боловсруулахад хяналт хэрэгжүүлдэггүй, хууль тогтоомжийн дагуу татвар суутган тооцоогүй зэрэг алдаа зөрчил байсан тул 2023 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагааг *"ХАНГАЛТТАЙ БУС"* гэж дүгнэсэн.<br>Шалгалтын явцад нийт 249.5 мянган төгрөгийн 3 төрлийн зөрчил илрэч үүнээс 1 зөрчилд 102.4 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага гаргаж, 1 зөвлөмж өгч арга хэмжээ тооцсон.<br>Акт, Албан шаардлага, Зөвлөмжийн биелэлтийг тус байгууллагын 2024.05.03-ны өдрийн 18 дугаар албан тоотоор хариу ирүүлж зөрчлийг арилгаж ажилласан байна. | **04** | 100% |
| 2.6 | Удирдах дээд шатны байгууллага, бусад төрийн байгууллага болон иргэний өргөдөл гомдлын дагуу ***"Төлөвлөгөөт бус хяналт шалгалт"*** гүйцэтгэх | Хяналт шалгалтын тоо | - | 5 | 1. **"Үйлсбадрах ӨЭМТ" /төлөвлөгөөт бус/**<br>Орхон аймгийн Засаг даргын орлогчоор батлуулсан 2024 оны 01 сарын 15-ны өдрийн баталсан 05/24 удирдамжийн хүрээнд "Үйлсбадрах ӨЭМТ"-ийн санхүүгийн ажилчдаас гаргасан өргөдлийн дагуу төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтыг тус ӨЭМТ-ийн санхүүгийн баримт материалд тулгуурлан хийж гүйцэтгэлээ.<br>Шалгалтаар өргөдөлд дурьдсан 8 асуудлаас 3-р асуудал буюу ӨЭМТ-ийн 2023 оны бүтэц орон тоонд "Эрүүл мэндийн даатгалын ажилтан"-ны орон тоо батлагдаагүй мөн хавсран ажиллах нэмэгдэл тусгагдаагүй нийт 2,530.0 мянган | 01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөгийн нэмэгдлийг олгосон байсанд нөхөн төлбөрийн 1 акт тогтоож зөрчлийг арилгуулсан.<br>Зөрчлийн биелэлтийг Үйлсбадрах ӨЭМТ-ийн 2024.02.29-ны өдрийн 10 тоот албан бичгээр акт болон зөвлөмжийн хариуг ирүүлсэн байна.<br>**2. *Хот тохижуулах газар /Төлөвлөгөөт бус/***<br>Аймгийн Засаг даргын 2024.08.14-ны өдрийн 41/24 дүгээр баталсан удирдамжийн дагуу Хот тохижуулах газрын 2024 оны 01 сарын 01-нээс 08 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацааны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийж 2025 оны төсвийн санал бодитой эсэхэд дүгнэлт өгч ажилласан. Дүгнэлтээр АЗД-д Хот тохижуулах газар нь 2024 оны төсвийн төсөлд тусгуулахаар 1,185,357.6 мянган төгрөгийн саналыг хүргүүлсэн байна. Шалгалтаар төсвийн төслийн дэлгэрэнгүй тооцооллыг хянан үзэхэд 776,889.9 мянган төгрөгөөр саналыг хүргүүлэх нь үндэслэл бүхий гэж үзээд, төслийн саналын зөрүү 408,467.60 мянган төгрөг байгааг дурьдсан байна.<br>**3. *Татварын хэлтэс /Төлөвлөгөөт бус/***<br>Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн СХШХ/07 тоот баталсан "Татварын Ерөнхий газар болон түүний харьяа газар, хэлтсийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын нэгдсэн удирдамж"-ийн дагуу Татварын хэлтсийн 2022 он, 2023 оны төсөв санхүүгийн үйл ажиллагаа болон улс, орон нутгийн төсөвт оруулах татварын орлогын бүрдүүлэлт тайлагналт, татварын хөнгөлөлт чөлөөлөлт, иргэн аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчийн газрыг эзэмшиж ашигласны төлөө ногдуулсан төлбөрийг төвлөрүүлсэн байдал зэргийг хамруулан | 08<br><br>09 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөт бус санхүүгийн хяналт шалгалтыг хийгдлээ.<br>Шалгалтаар улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө давж биелүүлсэн 2022-2023 онуудын төсөв санхүүгийн үйл ажиллагаа болон татварын үйл ажиллагаатай холбоотой бүртгэл хөтлөлт, тайлагналыг "ХАНГАЛТТАЙ" гэж дүгнээд 3 зөвлөмжийг өгсөн.<br>Зөвлөмжийн биелэлтийг Татварын газрын даргын 2024.11.15-ны өдрийн 01/733 дугаар албан тоот бичгээр ирүүлсэн байна.<br>***4.Хот тохижуулах газар /Төлөвлөгөөт бус/***<br>Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Хот тохижуулах газрын 2024 оны 10 сарын 31-ны байдлаархи төсвийн гүйцэтгэл, 2025 оны төсвийн төсөлд төлөвлөгөөт бус дотоод аудит хийгдлээ.<br>Тус аудитаар нийт 9 төрлийн зардалд 28,800.3 мянган төгрөгийг хэмнэх нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, хэмнэлтийн горим, Төсвийн тухай хуульд заасан зарчмын хүрээнд хэмнэгдэх боломжтой. Байгууллагын хүргүүлсэн 16,056,268.1 мянган төгрөгийн саналаас Санхүү төрийн сангийн хэлтэс 15,324,053.9 мянган төгрөгөөр хянасан ба СХДАА-ны хийгдсэн аудитаар 28,800.3 мянган төгрөгийг хэмнэх боломжтойг дурьдаад 15,295,253.9 мянган төгрөгөөр төсөв батлуулах саналыг хүргүүлж ажилласан байна.<br>Аудитаар өгсөн 6 зөвлөмжийн биелэлтийг Хот тохижуулах газрын 2024.12.13-ны өдрийн 716 тоот албан бичгээр ирүүллээ. | 11 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ***5.Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа УТҮГ /Төлөвлөгөөт бус/***<br><br>Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу тус байгууллагын 2024 оны 10 сарын 31-ны байдлаархи төсвийн гүйцэтгэл, 2025 оны төсвийн төсөлд төлөвлөгөөт бус дотоод аудит хийгдлээ.<br><br>Тус аудитаар нийт 2 төрлийн зардалд нийт 3,620.0 мянган төгрөгийг хэмнэх нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, хэмнэлтийн горим, Төсвийн тухай хуульд заасан зарчмын хүрээнд хэмнэгдэх боломжтой байна. Байгууллагын хүргүүлсэн 547,789.6 мянган төгрөгийн саналаас Санхүү төрийн сангийн хэлтэс 544,112.9 мянган төгрөгөөр хянасан ба СХДАА-ны хийгдсэн аудитаар 3,620.0 мянган төгрөгийг хэмнэх боломжтой гэж үзвэл 540,492.6 мянган төгрөгөөр төсөв батлуулах саналыг хүргүүлсэн.<br><br>Аудитаар өгөгдсөн 4 зөвлөмжийн биелэлтийг Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны 2024.12.13-ны өдрийн 32 тоот албан бичгээр ирүүлсэн байна. | 11 | |
| 2.7 | Өмнөх оны дуусаагүй ажлыг мэдээлэх | Байгууллагын тоо | - | 1 | Уран эгшиг сургуульд хийгдсэн шалгалтаар 2 албан шаардлага, 5 зөвлөж өгөгдөж, Сургуулийн захирлын 2023.12.28-ны өдрийн 173 дугаар албан тоотоор биелэлтийг хангуулсан. | 01 | 100% |
| 2.8 | Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар гүйцэтгэсэн хяналт шалгалтын тоон тайлан мэдээг гаргах | Тоон тайлан **/4 удаа/** | - | 4 | Дотоод аудитын дүрэмд заасны дагуу 1-р улирлын тоон тайланг 04 сарын 05-нд, 2-р улирлын тоон тайланг 2024 онд 06 сарын 03-нд, 3-р улирлын тоон тайланг 2024.10.07-нд, 4-р улирлын тоон тайланг 2024.12.13-нд тус тус гарган Ахлах мэргэжилтэнд мэдээлэлд нэгтгүүлсэн байна. | 4,6,9,12 | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Тоон тайланг улирал бүр гаргахын зэрэгцээ эрсдэлийн үнэлгээг тухай бүр нь хийж ХШҮХМ-нд нэгтгүүлсэн байна. | | |
| ***ЗОРИЛТ-3 Төрөөс баримтлах хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах*** | | | | | | |
| 3.1 | Албан хаагчдын мэдэгдэл тайлбар, ХАСУМ болон ХАСХОМ хуулийн хугацаанд гаргаж мэдүүлэх | 100% | - | 100% | Төрийн албан хаагчийн ХАСХОМ-ыг 2024.02.06-нд гарган албаны ЭБАТ-д хуулийн хугацаанд хүлээлгэн өгч бүртгүүлсэн. | 02 | 100% |
| 3.2 | Албаны хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлэх | 100% | - | 100% | Хяналт шалгалтын материалууд, чанарын дотоод аудитын баримт материал, АТГ-тай холбоотой бусад бичиг баримтуудыг эмхэлж цэгцлэн албан хэргийн стандартад заасны дагуу архивын нэгж үүсгэн цахимаар болон цаасаар бэлтгэн Архив бичиг хэргийн эрхлэгчид 2024.01.27-ны өдөр хүлээлгэн өгсөн байна. | 01-12 | 100% |
| **3.3** | "Тэрбум мод хөдөлгөөн", "Ногоон-Эрдэнэт хөтөлбөр"-ийн хүрээнд ногоон байгууламж нэмэгдүүлэх | Тарих модны тоо-5ш | - | 7ш | Тарлан толгой уулын энгэрт 5 сар болон 7 сард 2 удаагийн тарилтаар албан хаагч буюу нийт 7ш агч модыг, голт бор модыг тарьж ургуулсан. | 05-10 | 100% |
| 3.4 | Захиргааны III байрны гадна талбайн хуваарьт 50м2 газрын цас, хог, шарилжийг тухай бүрт цэвэрлэж хэвших | 100% | - | 100% | Тус байрны гаднах талбайд 50м2 талбайд бүх нийтийн цэвэрлэгээг хийж трактортой хөшөөг угааж цэвэрлэв. Мөн бусад талбайд 2 удаа хог түүх хуурай цэвэрлэгээ хийсэн. | 04 | 100% |
| **3.5** | Албаны даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулах, цаг ашиглалт, бүтээмж, үр нөлөөг сайжруулах ажил зохион байгуулах, төлөвлөгөөнд тусгах **/31 арга хэмжээг төлөвлөсөн/** | 100% | - | 100% | Албаны даргатай төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2024.03.05-ны өдөр байгуулж 31 арга хэмжээг төлөвлөж ажилласан. | 03 | 100% |
| 3.6 | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр | 100% | - | 100% | Тус гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг 2024.06.14-ны өдөр, жилийн эцсийн биелэлтийг 2024.12.16-ны өдөр дүгнүүлэхээр тус тус тайлагнав. | 06-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаргаж дүгнүүлэх **/31 арга хэмжээг дүгнүүлэх/** | | | | | | |
| **ЗОРИЛТ-4 Чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх** | | | | | | | |
| 4.1 | Санхүүгийн хяналт шалгалтын стандарт болон Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөх, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг стандартын дагуу гүйцэтгэх, www.audit.mof.gov.mn дотоод аудитын мэдээллийн системд иж бүрэн байршуулах | Байгууллагын тоо | - | 15 | Дотоод аудитын удирдлагын нэгдсэн системд 3 байгууллагын мэдээллийг оруулж бүртгэсэн. Уг системд хөгжүүлэлттэй холбоотой программын зарим үзүүлэлтүүд орохгүй байгаатай холбогдуулан Ахлах мэргэжилтэн заавар зөвлөгөө өгсөний дагуу мэдээллийг оруулахаар хүлээгдэж байна. | 03-12 | 28% |
| 4.2 | Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх | 100% | - | 100% | Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг баримтлан тайлант хугацаанд ямар нэгэн ёс зүйн зөрчилд холбогдоогүй ажилласан байна. | 01-12 | 100% |
| 4.3 | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, "Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх | 100% | - | 100% | Албаны гаргасан хөтөлбөр арга хэмжээний хуваарийн дагуу Чанарын дотоод аудит, Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хариуцаж ажиллалаа.<br>Эдгээр хөтөлбөр арга хэмжээний биелэлтийг эхний хагас жил, жилийн эцсийн байдлаар хэрэгжүүлж тайлагнаж ажиллав. | 01-12 | 100% |
| ***ЗОРИЛТ-5 Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах*** | | | | | | | |
| 5.1 | Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөж, архив, албан хэрэг хөтлөлтийг эрхлэн явуулах | 100% | - | 100% | Албанд мөрдөгдөж буй "Баримт бичиг боловсруулах хяналт тавих журам"-ын дагуу албан бичиг баримтын боловсруулалтыг архив бичиг хэргийн стандартад нийцүүлэн архивын нэгж үүсгэн бичиг хэргийн ажилтанд жил бүр цахим файлаар болон баримтаар жагсаалт үйлдэн хүлээлгэн өгч хэвшсэн. | 01-12 | 100% |



96

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2024 оны хяналт шалгалтын баримт материал болон бусад тайлан мэдээг цахимаар болон цаасан хэлбэрээр тайлант хугацаанд архивлан ажиллаж байна. | | |
| 5.2 | Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын магадлах аудитад хамрагдах /Чанарын дотоод аудит хийх/ | Аудитын тоо-2 удаа | - | 2 | Чанарын дотоод аудит хийх ажлын төлөвлөгөө, хөтөлбөр хуваарийн дагуу эхний хагас жилийн чанарын дотоод аудитыг 4-10 дугаар бүлийг 26 шалгуур үзүүлэлтийг хамруулан 04 сарын 29-нд хийж гүйцэтгэсэн. Тус аудитаар 7 тохиолдол, 2 зөвлөмж өгөгдөж стандартын хэрэгжилт 92.5%-тай дүгнэгдсэн. Чанарын ажлын хэсгээс биелэлтийг ирүүлж ажилласан байна.<br>Жилийн эцэст чанарын аудитыг 4-р улиралд хийхээр төлөвлөн албаны даргаар удирдамж батлуулан, төлөвлөгөө гарган аудит хийгдэж байна. Аудитын дуусах хугацаа хараахан болоогүй байна. | 04-12 | 100% |
| 5.3 | Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 стандартын магадлан аудитад хамрагдах /чанарын дотоод аудит хийх/ | Аудитын тоо-2 удаа | - | 2 | Чанарын дотоод аудит хийх ажлын төлөвлөгөө, хөтөлбөр хуваарийн дагуу эхний хагас жилийн чанарын дотоод аудитыг 4-10 дугаар бүлийг 30 шалгуур үзүүлэлтийг хамруулан 04 сарын 29-нд хийж гүйцэтгэсэн. Тус аудитаар 5 тохиолдол, 6 зөвлөмж өгөгдөж стандартын хэрэгжилт 92.8%-тай дүгнэгдсэн. Чанарын ажлын хэсгээс биелэлтийг цаасаар ирүүлж ажилласан байна.<br>Жилийн эцэст чанарын аудитыг 4-р улиралд хийхээр төлөвлөсөн ба өмнөх магадлан аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтэд чиглүүлэн гүйцэтгэхээр ажлын төлөвлөгөө, удирдамжийг албаны даргаар батлуулан ажиллаж байна. Дуусах хугацаа хараахан болоогүй байна. | 04-12 | 100% |
| 5.4 | И-оффис системийн ашиглалтыг сайжруулах | 100% | - | 100% | Төрийн албан хаагчийн тухайн сард хийх ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг тухай бүр | 01-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | И-оффисс системд оруулж системийн ашиглалтыг сайжруулан ажиллаж байна. Тайлант хугацаанд хар жагсаалтад орсон тоон үзүүлэлт одоогоор байхгүй байна. | | |

***Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт***

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн , дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Тусгайлан өгөгдсөн үүрэг даалгавар байхгүй болно. | - | - | - | - | - | - |

***Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт***

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2.1 | Мэргэших болон бусад сургалтанд хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх /Мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтанд суух/ | Сорил шалгалт өгөх, МНБ-ийн 1-2 хичээлийн эрхийн үнэлгээ | - | 100% | Тайлант хугацаанд үндсэн хяналт шалгалтын зэрэгцээ төлөвлөгөөт бус хяналт шалгалтууд ихээр давхцаж бие даан давтах хугацаа хомс байсан тул 2025 оны хавар албан ёсны ээлжийн амралтын хугацаанд шалгалтыг өгөхөөр төлөвлөж чөлөөт цагаараа хичээлээ бие даан судалж байна. | 05-12 | 50% |
| 2.2 | Дотоод аудитын чиглэлээр сурч, мэргэшиж, дадлагажих | Сургалтын тоо | - | 1 | Тайлант хугацаанд 19011 Чанарын дотоод аудитын сургалтанд 2024 оны 6 сард цахимаар хамрагдлаа. Тус сургалтыг Стандарт хэмжилзүйн газраас чанарын дотоод аудитор бэлтгэх сургалт 2024.06.25 болон 26-ны өдрүүдэд зохион байгуулагдаж амжилттай хамрагдсан гэрчилгээ авч мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн байна. | 06 | 100% |
| 2.3 | "Монгол бичиг"-ийн мэдлэг, чадвар, түвшингээ ахиулах | Чадвар сайжирна | - | 100% | "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III"-ын 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлын хүрээнд зохион байгуулсан | 05-12 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Үндэсний бичгийн дүрмийн сургалт"-д хамрагдан сертификат авсан. Мөн албаны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан монгол бичгийн сургалтад тогтмол хамрагдлаа. | | |
| 2.4 | Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагаа дээшлүүлэх /"Soft skills" буюу зөөлөн ур чадвар суулгах / Үүнд Суралцах ур чадварыг төлөвшүүлэх/ | Ёс зүйн зөрчлийн тоо, зөөлөн ур чадвар эзэмших | - | 100% | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөөлөн ур чадварт гадагт ажил мэргэжлийн чиглэлээр Дотоод аудитор нарт мэдлэгээ хуваалцах, заавар зөвлөгөө өгөх, дагалдуулж дадлагажуулах, заавар зөвлөгөө өгөхөд түлхүү анхаарч ажиллалаа. | 01-12 | 100% |
| 2.5 | Төрийн албаны тухай хуулийн 29-д заасны дагуу богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах | Хамрагдсан сургалтын сертификат | - | 100% | **1.**2020 онд Удирдлагын академи Төрийн албаны сургуулиас зохион байгуулсан төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтанд хамрагдаж №R0145 дугаар бүхий сертификат авсан.<br>**2.**2024 оны 6 сард Стандарт хэмжилзүйн газраас зохион байгуулсан MNS ISO 19011:2020 Менежментийн тогтолцоонд аудит явуулах заавар сэдэвт сургалтын төлөвлөгөөний дагуу бүтээгдэхүүн тогтолцооны баталгаажуулалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Чимгээгийн сургалтад 2 өдрийн турш хамрагдаж гэрчилгээ авч мэдлэг, ур чадвараа дээшлүүллээ.<br>**3.**Байгууллагын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан бусад сургалтад тухай бүр нь хамрагдсан байна. | -<br>06<br>01-12 | 100%<br>100%<br>100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ДОТООД АУДИТОР,САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ (О.БОЛОРМАА)........ 2024.12.05

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

90

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
10 дугаар хавсралт

# ДОТООД АУДИТОР-САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ О.БОЛОРМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ДОТООД АУДИТОР-САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ О.БОЛОРМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба

**Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| ***ЗОРИЛТ-1 "БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД*** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 1.2. | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Арга хэмжээ 1.3. | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | Арга хэмжээ 1.4. | 60 | 10 | 70 | 70 |
| 5. | Арга хэмжээ 1.5. | 30 | 0 | 30 | 30 |
| ***ЗОРИЛТ-2 ХАРИУЦЛАГЫН ТОГТОЛЦООГ ТӨЛӨВШҮҮЛЖ, САНХҮҮГИЙН САХИЛГА БАТЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ*** | | | | | |
| 6. | Арга хэмжээ 2.1 | 60 | 10 | 70 | 70 |
| 7. | Арга хэмжээ 2.2. | 60 | 10 | 70 | 70 |
| 8. | Арга хэмжээ 2.3. | 60 | 10 | 70 | 70 |
| 9. | Арга хэмжээ 2.4. | 60 | 10 | 70 | 70 |
| 10 | Арга хэмжээ 2.5. | 60 | 10 | 70 | 70 |
| 11. | Арга хэмжээ 2.6. | 60 | 10 | 70 | 70 |
| 12. | Арга хэмжээ 2.7. | 60 | 10 | 70 | 70 |
| 13. | Арга хэмжээ 2.8. | 60 | 10 | 70 | 70 |
| ***ЗОРИЛТ-3 ТӨРӨӨС БАРИМТЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ*** | | | | | |
| 14. | Арга хэмжээ 3.1. | 60 | 10 | 70 | 70 |
| 15. | Арга хэмжээ 3.2. | 60 | 10 | 70 | 70 |
| 16. | Арга хэмжээ 3.3. | 60 | 10 | 70 | 70 |
| 17. | Арга хэмжээ 3.4. | 60 | 10 | 70 | 70 |
| 18. | Арга хэмжээ 3.5 | 60 | 10 | 70 | 70 |
| 19. | Арга хэмжээ 3.6 | 60 | 10 | 70 | 70 |
| **ЗОРИЛТ-4 Чадахуйн зарчимд суурилсан чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх** | | | | | |
| 20. | Арга хэмжээ 4.1. | 20 | 8 | 28 | 28 |
| 21. | Арга хэмжээ 4.2. | 60 | 10 | 70 | 70 |
| 22. | Арга хэмжээ 4.3. | 60 | 10 | 70 | 70 |
| ***ЗОРИЛТ-5 Мэдээллийн ил тод, аюулгүй байдлыг хангах*** | | | | | |
| 23. | Арга хэмжээ 5.1. | 60 | 10 | 70 | 70 |
| 24. | Арга хэмжээ 5.2. | 60 | 10 | 70 | 70 |
| 25. | Арга хэмжээ 5.3. | 60 | 10 | 70 | 70 |
| 26. | Арга хэмжээ 5.4. | 60 | 10 | 70 | 70 |
| **НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (арга хэмжээ) -ЫН БИЕЛЭЛТ** | | | | | |
| **Дундаж оноо:** | | | | **66.8** | **66.8** |

**2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 27. | Арга хэмжээ 2.1. | 50 | 7 | 7 |
| 28. | Арга хэмжээ 2.2. | 100 | 15 | 15 |
| 29. | Арга хэмжээ 2.3 | 100 | 15 | 15 |
| 30. | Арга хэмжээ 2.4. | 100 | 15 | 15 |
| 31. | Арга хэмжээ 2.5. | 100 | 15 | 15 |
| | **Дундаж оноо** | | **13.4** | **13.4** |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | 7 |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 7 | 7 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 1 | 1 |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | 7 |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | 7 |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | - | - |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | - | - |
| | **Дундаж оноо** | **5,8** | **5,8** |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| | **Дундаж оноо** | **8** |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | **66,8** |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | **13,4** |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | **5,8** |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | **8** |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | **-** |
| | **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)*) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | **94** |

***Үнэлгээ өгсөн:***

Ахлах мэргэжилтэн, Дотоод аудитор-СХШУБ ............................ /Л.Булганцэцэг/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.15 ............ *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Дотоод аудитор-СХШУАБ ............................ /О.БОЛОРМАА/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.15 ............ *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан: Нэгжийн дарга***

Албаны дарга-СХШУАБ ............................ /Д.САЙЗМАА/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2024.12.15 ............ *(огноо)*